

40. OUTBREAKS OF INFLUENZA IN MONGOLIA AT THE BEGINNING OF XX CENTURY

L.Enkhbaatar, A.Burmaa

National Center for Communicable Diseases

It is still unknown among epidemiologists whether there were influenza outbreaks before 1970 when influenza surveys have started to be carried out in Mongolia. However in 1918, 1957, 1968 and 1977 there were four pandemic outbreaks of influenza that affected the whole world. In terms of epidemiology it is an interesting question whether these pandemic outbreaks affected Mongolia as it has distinctive nature and geography, vast territory and small a population with prevailing nomadic agriculture. In this research, using retrospective research method of historical sources dating back to 1900-1970 we attempted to identify whether there were pandemic outbreaks of influenza in Mongolia.

Research findings. According to information and documents that we have found, in the book "Modern Mongolia" written by I.M.Maisky, the Russian historian and academician, who used to work in Autonomous Mongolia in 1919 -1920, it was recorded that in 1918 the disease which is called influenza by local Russians spread throughout the country and killed large number of Mongolians, and there were cases when corpses were left in their homes for long time without being known. Other researchers stated that there was an outbreak of influenza in 1944 in Ulaanbaatar city and in this respect the Public Health Ministry issued the Order No.19 on 19 January 1944 to implement the resolution of the Minister's Council of 12 January 1944 to fight against influenza. This time the condition of patients has deteriorated and 50 percent of military force was communicated by influenza. In February 1947 there was a repeated outbreak of influenza epidemic in Ulaanbaatar city due to which the Public Health Ministry issued the order No.77 on measures to fight against this disease. In 1948 and at the end of March in 1949 there was another outbreak of influenza epidemic, and during this outbreak students of Medical Vocational Schools were mobilized to help at the new department opened at the Central Hospital.

Conclusion. It can be concluded that there were outbreaks of influenza in Urguu and Ulaanbaatar cities until 1970s of XX century in particular in 1918, 1944 and 1947-1949. By the outbreak of 1918 a large number of population were killed. It is clear that in 1944 there was an outbreak that affected 50 percent of military force.

41. THE FOGARTY PROJECT: COOPERATION IN RESEARCH AND TRAINING IN ENVIRONMENTAL AND OCCUPATIONAL RISK FACTORS OF CARDIOVASCULAR DISEASE, SCHOOL OF PUBLIC HEALTH – HEALTH SCIENCES UNIVERSITY OF MONGOLIA AND BLOOMBERG SCHOOL OF PUBLIC HEALTH JOHNS HOPKINS UNIVERSITY

E.Silbergeld¹, C.Ochir²

¹Johns Hopkins Bloomberg School of Public Health Baltimore, MD USA,

²School of Public Health & Health Sciences University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

The overall goal of this five-year project is to support an NCD RTP program, involving the School of Public Health of the Health University of Mongolia (MSPH) and the Johns Hopkins Bloomberg School of Public Health (JHSPH), with the clear focus to build strong capacity in research and translation of research into public health intervention in order to empower the SPHM to identify and intervene to reduce preventable risk factors for cardiovascular disease in Mongolia, with an emphasis on environmental/occupational exposures related to mining and other metals exposure. Mongolia, a strategically positioned democratic country in Central Asia, is confronting the opportunities and challenges of abundant mineral and fossil fuel resources as well as geographic proximity to two major economic and political powers in the region (Russia and China). Cardiovascular disease is the leading cause of morbidity and mortality in Mongolia, with increasing rates over the past decade. Development of mineral resources (precious and non-ferrous metals, coal and fossil fuels) is the fastest growing sector in the Mongolian economy, involving both large- and small-scale operations. In addition, Mongolia is also rapidly urbanizing while at the same time preserving many traditional aspects of lifestyle. The project has three specific aims: (1) to carry out programs in training for capacity building in research and intervention science, including doctoral training at JHSPH, short term fellowships ("sandwich" grants) for research PhD students at MSPH to come to JHSPH; and courses to

be held in Mongolia through MSPH.; (2) to develop an exposure assessment laboratory, including equipment and expertise to carry out environmental and workplace exposure assessment, biomonitoring, and modeling, and (3) to conduct in-country research projects for an

NCD RTP program that implement capacity building, through newly developing opportunities, that will empower training in research skills and acquisition of critical knowledge needed to develop national programs in chronic disease prevention and intervention science.



вакциныг хийх, түүнийгээ турших, хүчин чадлыг нь тогтоох зэрэг үйл ажиллагааг голчлон явуулж байна. Хоёрдахь баг нь хөл ба амны өвчний, Рифт хөндийн халууралтын, томуугийн, түүнчлэн байгаль дэлхий дээрх хөгжлийн явцад болон инженерийн аргаар бий болсон үл мэдэгдэх шинэ эмгэг төрөгчдийг богино хугацаанд илрүүлэх оношлуурыг бий болгох зэрэг үйл ажиллагааны дүнд вакцины багт дэмжлэг үзүүлж байдаг. Гуравдахь баг нь ноцтой эмгэг төрөгчөөр үүсгэгдсэн тохиолдолын үед салбар хоорондын, байгууллага хоорондын улмаар олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх шугамаар АНУ-ын үндэсний бодлого болон хариу арга хэмжээг дэмжих зорилготой. Зоонозын ба Шинээр тархаж буй өвчний тусгай төвийн боловсролыг онцгойлон анхаарч өргөн хүрээгээр хөгжүүлэх гэсэн эрхэм зорилгыг дэмжиж “Нэг эрүүл мэнд” үзэл баримтлалыг нэгдмэл болгох болно.

40. ХХ ЗУУНЫ ЭХЭН ҮЕД МОНГОЛ УЛСАД ТОХИОЛДСОН ТОМУУГИЙН ДЭГДЭЛТҮҮД

Л.Энхбаатар, А.Бурмаа

Халдварт Өвчин Судлалын Үндсэний төв

Тус улсад томуу өвчний тандалт явагдаж эхэлсэн 1970-д оноос өмнө томуу өвчний дэгдэлт явагдаж байсан уу гэдэг нь манай томуу болон тархвар судлаач нарын дунд одоо хүртэл тодорхойгүй байна. Гэтэл ХХ-р зууны 1918, 1957, 1968, 1977 онуудад дэлхий дахиныг хамарсан томуугийн 4 том цар тахал гарсан бөгөөд уг цартахлууд байгаль газар зүйн өвөрмөц онцлогтой, өргөн уудам газар нутагтай, хүн ам багатай нүүдлийн аж ахуй давамгайлсан тус улсад гарч байсан уу гэдэг нь тархвар судлалын хувьд сонирхол татаж байна. Судалгаанд 1900-1970 оны хоорондох түүхэн зарим эх сурвалжыг эргэмж судалгааны аргаар томуугийн цартахал, дэгдэлт гарч байсан эсэхийг тодорхойлох оролдлого хийв.

Судалгааны үр дүн: Бидэнд олдсон мэдээ баримтаар 1919-1920-д онд Автономит Монгол улсад ажилласан Оросын түүхч, академич И.М.Майскийн туурвисан “Орчин үеийн Монгол” номонд 1918 онд эндхийн суурьшсан оросуудын нэрлэгдээр инфлуэнц хэмээх өвчин орон даяар тархаж, монголчуудыг баруун солгойгүй хиаруулсан ба заримдаа гэрээрээ нас барсан цогцсыг нь хүн мэдэлгүй гэр оронд нь удаасан явдал ч гарсан гэж тэмлэглэжээ. Мөн зарим судлаачдын үзэж буйгаар 1944 онд Улаанбаатар хотод томуугийн дэгдэлт гарсан бөгөөд үүний дагуу 1944 оны 1-р сарын 12-нд СнЗ-ын томуу өвчинтэй тэмцэх

тухай тушаал тогтоолыг биелүүлэх ЭХЯ-ны 19-р тушаал 1-р сарын 19-нд гарчээ. Тухайн үеийн байдлаар өвчлөл их хүндэрч байсан бөгөөд цэргүүдийн 50% томуугаар өвчилж байсан байна. 1947 оны 2-р сард Улаанбаатар хотод томуугийн эпидеми дахин гарч уг өвчинтэй тэмцэх арга хэмжээний тухай ЭХЯ-ны 77-р тушаал гарчээ. 1948, 1949 оны 3-р сарын сүүлчээр Улаанбаатар хотод томуугийн эпидеми дахин гарч хүн эмнэлгийн техникумын сурагчдыг дайчилж, Төв эмнэлэгт тасаг нээж байсан байна.

Дүгнэлт:

Хорьдугаар зууны далаад он хүртэл 1918, 1944, 1947-1949 онуудад Өргөө болон Улаанбаатар хотуудад томуугийн дэгдэлт гарсан гэж үзэж болох юм. Үүнээс 1918 онд олон хүн амыг хируулсан, 1944 онд цэргийн ангийн 50% хамарсан томуугийн дэгдэлт гарсан нь тодорхой байна.

41. ЗҮРХ СУДАСНЫ ӨВЧИНД НӨЛӨӨЛӨХ ХҮРЭЭЛЭН ОРЧИН БОЛОН МЭРГЭЖЛИЙН ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛИЙН СУДАЛГАА, СУРГАЛТ

Эллен Зилбергелд¹, О. Чимэдсүрэн²

¹АНУ, Балтимор, Блумбергийн Жонн Хопкинсийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль

²Монгол улс, Улаанбаатар, Монголын Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль

Таван жилийн хугацаанд хэрэгжүүлсэн энэхүү төслийн үндсэн зорилго нь Монголын Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль болон Блумбергийн Жонн Хопкинсийн Их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн оролцоотойгоор NCD RTP хөтөлбөрийн хүрээнд эрдэм шинжилгээний чадавхийг нэмэгдүүлэх, SPHM-ийн боловсон хүчнийг нийгмийн эрүүл мэндийн судалгаанд татан оролцуулах, уул уурхай болон ашигт малтмалын олборлолттой холбоотой үүсэх зүрх судасны өвчнүүдийн сэргийлж болох боломжтой хүрээлэн орчны болон мэргэжлийн эрсдэлт хүчин зүйлийг Монголд бууруулахад оролцох зэрэг болно. Монгол улс нь эрдэс баялаг, чулуужсан түлшний нөөц ихтэй, бүс нутагтаа газарзүйн хувьд улс төрийн болон эдийн засгийн хоёр том гүрэнтэй (Орос, Хятад) ойрхон оршдог зэрэг давуу тал, боломж ихтэй стратегийн ашигтай байрлал бүхий ардчилсан улс. Сүүлийн 10 жилд зүрх судасны өвчний өвчлөлийн

түвшин нэмэгдэж Монгол улсын хэмжээнд бүртгэгддэг өвчлөл, нас баралтын дотор тэргүүлэх байрыг эзлэж байна. Сүүлийн жилүүдэд Монголын эдийн засагт эрдэс баялагийн орд, нөөц (төмөр, төмрөөс бусад металл, нүүрс, чулуужсан түлш)-ийг илрүүлэх олборлох салбар их, бага хэмжээний цар хүрээгээр хурдацтай хөгжсөн. Түүнчлэн энэ хугацаанд Монгол улс маш хурдан хотжиж байгаа боловч амьдарлын уламжлалт хэв маягууд хадгалагдсаар байна. Энэхүү төсөл нь дараахь гурван зорилтыг дэвшүүлсэн: 1) эрдэм шинжилгээний чадавхийг нэмэгдүүлэх болон шинжлэх ухааны мэдээллийг харилцан солилцох сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд Жонн Хопкинскийн Нийгмийн эрүүл

мэндийн сургуульд докторантын сургалтыг зохион байгуулах, Монголын Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн АУ-ны боловсролын докторын зэрэг горилох сургалтанд хамрагдаж буй судлаачдыг Жонн Хопкинскийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн богино хугацааны ("сэндвич" грант) сургалтанд хамруулах.; 2) багаж төхөөрөмжийг сайжруулах замаар лабораторийн үнэлгээг хөгжүүлэх болон хүрээлэн орчин, ажлын байрны үнэлгээнд шинжилгээ хийх, мөн биомонитор болон загвар гаргах мөн 3) NCD RTP хөтөлбөрийн хүрээнд боловсон хүчнийг эрдэм шинжилгээ судалгаанд сургаж дадлагажуулах замаар салбарыг чадавхижуулах шинэ боломжуудыг хэрэгжүүлэх, мөн шинжлэх ухааны мэдээллийг солилцох болон архаг өвчнөөс сэргийлэх үндэсний хөтөлбөрийг хөгжүүлэхэд шаардагдах сайн мэдлэгийг эг чиглэлийн төслүүдийг улсын хэмжээнд йгуулах.

